



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

№119 /563/

2023.08.02

Цаг үе, үйл явдал

ХАНХӨХИЙН ГАВЬЯАТ ХУРАНДАА



Ажил, амьдралынхаа 50 гаруй жилийг Бурхантын хөндийд Дархан хотыг бүтээн байгуулах гэгээн мөртэй эрхэм үйлсэд зориулсан Монгол Улсын Гавьяат барилгачин, чөлөөнд байгаа хурандаа Манкадайн Мөнхбатын тухай өгүүлсэн “Ханхөхийн гавьяат хурандаа” дурсамж, дурдатгалын номын авшиг хүртээх ёслол Зэвсэгт хүчний Барилга-инженерийн цэргийн удирдах газрын хурлын танхимд болов.

Номын дээжийг алгандаа гардах хүндтэй урилгыг Барилга-инженерийн цэргийн удирдах газрын орлогч, штабын дарга хурандаа Ж.Баясгалан, Барилга-инженерийн цэргийн Ахмадын хорооны удирдах зөвлөлийн дарга, Гавьяат барилгачин, бэлтгэл хошууч генерал П.Доржсүрэн, “Монгол хурандаа” нийгэмлэгийн тэргүүн, Гавьяат багш, чөлөөнд байгаа хурандаа Ч.Баатар, Зэвсэгт хүчний 017 дугаар ангийн захирагч хурандаа Б.Дорждэрэм, тус ангийн Дархан хот дахь Ахмадын зөвлөлийн дарга, чөлөөнд байгаа дэд хурандаа О.Дэжид, Барилгын цэргийн ангиудын захирагчаар ажиллаж байсан чөлөөнд байгаа хурандаа С.Сосорбурам, Д.Нямаа, М.Төмөрбаатар, Г.Мягмардорж, П.Наваансүрэн, хамтран зүтгэж явсан нөхөд, хань, үр хүүхдүүд, төрөл төрсөд хүлээн авч хүрэлцэн иржээ.

Ёслолын арга хэмжээг Барилга-

инженерийн цэргийн Ахмадын хорооны гүйцэтгэх захирал, чөлөөнд байгаа хурандаа П.Наваансүрэн хөтлөн явуулав. Буурал хурандаад номоо бүтээхийг шахаж шаардаж, зөвшөөрүүлж, улмаар өөрөө эмхэтгэн толилуулсан Соёлын тэргүүний ажилтан, бэлтгэл хурандаа С.Жигжид анхлан үгээ сонордуулав. Тэрээр “Мөнхбат хурандаа номынхоо эхний үсгээс эцсийн цэг хүртэл өөрийн гараар мутарлан бичсэн. Барилгын цэргийн мартагдах шахсан түүхийг сэргээхэд үнэтэй хувь нэмэр болсон бүтээл” болсон гэдгийг онцлов.

Барилгын цэргийнхний дунд “Жүүгий” нэрээр алдаршсан генералын хүү, хурандаа Ж.Баясгалан “Барилга инженерийн цэргийн бүрэлдэхүүнд ахмад үеийнхээ замналыг танин мэдэхэд ач холбогдол бүхий ном болсныг” тэмдэглэж хэллээ. Бэлтгэл хошууч генерал П.Доржсүрэн “Дархан хотын суурийг тавилцсан, Шинэ Үндсэн хуулийг эх баригч гээд М.Мөнхбат хурандаа залуу үеийнхэнд бахархах олон үйлсийг бүтээжээ”, хурандаа Б.Дорждэрэм “Дархан, Эрдэнэтийн олон арван бүтээн байгуулалтад түүний ур чадвар, хичээл зүтгэл шингэсэн”, чөлөөнд байгаа хурандаа Ч.Баатар “Бурхантын хүүхдүүд” номыг бүтээх явцад уулзаж ярилцсан хүмүүсийн сэтгэлийн дайтад Мөнхбат, Төмөрбаатар хурандаа нарын нэр олонтоо дурдагдаж байсан”, чөлөөнд

байгаа дэд хурандаа Д.Рагчаа “Барилгын цэргийн түүхийг өгүүлсэн одоогоор отгон бөгөөд даацтай бүтээл боллоо” гэж хэлэв.

М.Мөнхбат хурандаатай 10 жилд нэг ангийн сурагч явсан Ардын зураач Ц.Байды сургуульд байхдаа түүнийг Чапаев нэртэй байсан түүхийг дурдав. Иргэний дайны үеийн морин цэргийн домогт дарга Чапаевын тухай кино дэлгэцнээ гардаг жил мэндэлсэн тул эцэг эх нь цэргийн мундаг дарга болохыг билэгшээж энэ алдрыг хайрлажээ. Харин 10 дугаар ангиа төгсөөд ЗХУ-д сургууль явах болж нэрээ монгол болгосон аж. Ардын сургуульд тохой нийлүүлж суусан ангийн нөхдөөс нь хожим 10 гавьяат цолтон, нэг Ардын зураач төрсөн байна.

Хурандаа номондоо бага нас, ажил хөдөлмөрийн гараагаа эхэлсэн БЦ-ийн 111 дүгээр анги, Дархан хотын бүтээн байгуулалттай холбогдсон 017 дугаар ангийн хамт олон, аав, ээж, гэр бүлийнхээ амьдрал, хань Б.Цэрэндуламын дурсамж, дайчин нөхдийн сэтгэгдэл, бие сэтгэл оролцсон бүтээн байгуулалтын жагсаалтаа хавсаргасан нь хувь хүний намтар гэхээсээ илүү эх орныхоо бүтээн байгуулалтад жинтэй хувь нэмэр оруулсан Барилгын цэргийн бие бүрэлдэхүүний үүх түүх, гавьяат үйлсийг товойлгосон бүтээл гэж ойлгогдохоор байна.

“ЭХ ОРОНЧ ҮЗЭЛ ГЭДЭГ ЦЭРГИЙН АЛБЫГ ХҮНДЭТГЭХЭЭС ЭХЭЛНЭ”



Хошууч генерал Ч.Самбуугийн нэрэмжит, “Алтангадас” одонт Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийн Сургалтын төвд явагдаж байгаа “Оюутан цэрэг” цэргийн мэргэжил олгох сургалт төлөвлөгөөний дагуу амжилттай явагдаж, дайчдын үндэсний бахархлыг дээшлүүлэх, эх оронч үзэл хүмүүжлээр төлөвшүүлэх хүрээнд

уулзалт, ярилцлага, нөлөөллийн ажлыг явуулж байна.

Энэ сарын 2-ны өдөр бэлтгэлд байгаа хошууч генерал Б.Баярмагнайг урьж “Эх оронч үзэл ба монгол бахархал” сэдвээр сургалт явуулав. Тэрээр гурван сэдвийн хүрээнд буюу “Эх оронч үзэл гэж юу вэ?”, “Үндэсний бахархал”, “Монгол Улсын энхийг

сахиулах үйлс дэх оролцоо, түүний ач холбогдол” мэдээлэл өгч, оюутан цэргүүдийн санал сэтгэгдлийг сонсож, харилцан ярилцлаа.

Тухайлбал, монгол цэргүүд хилийн чанадад тэр дундаа энх тайван бус, улс төр, эдийн засгийн хүндрэлтэй улс оронд очсоныхоо дараа юугаар ч сольшгүй энх тайван, уудам амгалан эх орондоо энэ бие минь төрсөндөө бахархдаг, баярладаг. Амьсгалах агаар, хил хязгааргүй цэлийх газар нутгаараа бахаддаг хэмээгээд “Эх оронч үзэл гэж хэт бардам, хэт үндэсхэрхэг үзэлтэй байхыг хэлдэггүй” гэдгийг ч сануулж, харин цэрэг дайчдаа хүндэтгэж, хайрлахаас эхэлдэг гэлээ.

Төгсгөлд нь тэрээр та бүхний

гарт эх орных нь ирээдүй бий, зөв эр хүн байж, улс орондоо ихийг хийж бүтээхийг хүсэн ерөөсөн юм.

Мөн энэ сарын 03-ны өдөр хөтөлбөрийн дагуу тасгийн буудлагыг зохион байгуулж, тасгийн захирагч нарын тоотоо удирдах чадавч, байлдагч нар буудлагын ур чадварыг нь нэмэгдүүлэв. Энэ үеэр III ротын III салааны I тоотын байлдагч Э.Ган-Эрдэнэ, III тоотын байлдагч М.Бадар-Ууган нар 3 харвалтаас 3 онож, цэц мэргэнээрээ тодров. Дайчдадаа үлгэр жишээ болж, тус салааны захирагч дэслэгч Б.Сумъяабаатар нэг харвалтаар байг устгаж, манлайллыг биеэр үзүүлж, оюутан цэргүүдийн урам зоригийг нь сэргээж чадсан юм.

Ахлах дэслэгч Б.БЭРХБААТАР



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 20	🌧️ 12

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 33	🌧️ 21

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,450	3,461
EUR 🇪🇺	3,793	3,820
CNY 🇨🇳	484	489
RUB 🇷🇺	37.50	38.50
JPY 🇯🇵	23.90	24.30
KRW 🇰🇷	2.60	2.65

ЗУРХАЙ

2023.08.02 /ЛХАГВА ГАРАГ/
БИЛГИЙН ТООЛЛЫН 16

ЗУНЫ АДАГ ШАРАГЧИН ХОНЬ САР
ЕСӨН УЛААН МЭНГЭТЭЙ ХАР ЛУУ ӨДӨР

Үс засуулбал:

Өвчин ирнэ
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
05.29-20.28
Барилдлага:
Рашаан
ШҮТЭН БАРИЛДЛАГА:
Сэрэхүй

Тухайн өдөр гахай, хулгана, үхэр, луу, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр насны хүч дэлгэрнэ. Эм найруулах, угаал үйлдэх, бэр авах, насны авшиг, насны бүтээл хийх зан үйл хийгээд төрөл садан бололцох, худалдаа наймааны үйлнээ сайн болой, амраг лугаа золгох, авшиг авах, ус гатлах, угаах зэрэгт сайн. Баруун нүд татвал садан ирэх, зүүн нүд татвал баярлах, баруун чих хангинавал гутамшиг болох, зүүн хангинавал завхарсныг сонсож цочих, бие татвал өмнө зүгээс зочин ирэх, хөл татвал хэрүүл гомдол болно.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 691,780,238

Эдгэрсэн

Нийт: 664,602,158

Нас барсан

Нийт: 6,904,250

Цахим шууданд

"ЦЭРГИЙН ГЭРГИЙ НАР ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ХАМГИЙН ҮНЭНЧ ДЭМЖИГЧ НЬ БАЙДАГ"



тус ангийн захирагчаар ажиллаж байсан бэлтгэлд байгаа хурандаа Сэдийн Нэргүй байв. С.Нэргүй хурандаа анхны үрээ алдаад тэнгэр хол, газар хатуу байхад нь дуудаж "Нөхөр минь Афганистан руу ажиллагаанд яваад ир. Хорвоогийн жам хатуу, хэцүү бүхнийг нь жаахан ч гэсэн умартахад дарга нь ингэж л тусалъя. Эхнэртээ санаа зоволтгүй бид эргэж тойроод байж байя" гээд явуулсан, энэ нь ёстой нөгөө хүнээ боддог цэргийн даргын шийдвэр юм даа гэв. Дараа жил нь буюу 2014 онд С.Хүслэн-Эрдэнэ, 2017 онд С.Шүр-Эрдэнэ гэдэг цэцэг шиг хоёр охинтой болсон, ээж Б.Сэргэлэн нь Хэнтий аймгийнхаа Биндэр сумандаа амьдарч байгаа, насаараа модны үйлдвэрт ажилласан гарын ур дүйтэй эмэгтэй гэж онцлолоо. Эхээс зургуулаа, ах дүү, гэр бүлээсээ цэргийн амьдралаар амьдарч яваа нь тэр ганцаараа гэнэ.

Бэлтгэлд байгаа хурандаа С.Бямбаа цахим хуудаснаа "Хөдөө орон нутагт томилогдсон залуу офицер, ахлагчийн гараас нь хөтлөөд цугтаа явж байгаа охид бүсгүйчүүдээрээ бахадъя. Ингэж эхэлсэн амьдрал хамгийн гоё" гэж бичсэн нь олны талархлыг ихэд хүлээжээ. Үнэхээр л тийм. Дэслэгч бүр байлдагч нь байхад нь ханилан суугаад, үр хүүхдээ хөтлөн, хайрцаг саваа баглан боож цэргийн анги дамжин нүүсээр хатуу бэрхийг хамтдаа туулж яваа олон мянган бүсгүйчүүд бий. Эр нөхрийнхөө төлөө өөрийн ажил мэргэжлийг "золиосолж", үр хүүхдүүдээ хүмүүжүүлж, ар талаа дааж амьдарсан цэргийн гэргий нартай уулзаж ярилцахад ч дэндүү сайхан. Цэргийн албаны сайхныг магад тэд л илүү тодоор, утга уянгатай, баяр жаргал, талархлын нулимстайгаар ярьдаг байж мэднэ. Энэ удаа цэргийнхний ар тал болсон олон бүсгүйчүүдээс төлөөлөл болгож Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн хуягт техникийн албаны дарга, хошууч Сэргэлэнгийн Сод-Эрдэнэ болон түүний гэргий Баасангаравын Жавзандулам нарыг онцолж байна.

Хэнтий аймгийн Биндэр сумын хархүү, Архангай аймгийн Батцэнгэл сумын бүсгүй хоёр Дорнод аймагт нутаг сэлгэн амьдарснаар 12 жил өнгөрчээ. Анх таньж мэдэх хүнгүй, нөмөрлөж түших ах дүүгүй очсон цэргийн залуу, түүний гэргий хоёрт одоо бол энэ нутгаас илүү сайхангүй болсон гэнэ. Томилогдож ирээд удалгүй анхны үрээ алдаж хүнд цаг үеийг хамтдаа туулсан, өдгөө сайхан хоёр охиныхоо төлөө хичээж яваагаа хуучилсан нь бидний ярилцлагын хөндүүр сэдэв байв.

Хошууч С.Сод-Эрдэнэ 2006-2011 онд ҮБХИС-ийг хуягт танкийн албаны офицер мэргэжлээр дүүргэж, ЗХЖШ-ын даргын тушаалаар Зэвсэгт хүчний 327 дугаар ангид салааны захирагчаар томилогджээ. Ханьтайгаа сонсогч байхдаа ханилан суусан бөгөөд хүүтэйгээ гурвуулаа тус ангийн албан тушаалын байрны 36 тоотын хажуу өрөөнөөс гал голомтоо бадраажээ. Анх хоёр талаасаа өмссөн хувцастайгаа нийлж байсан бол өдгөө өнөр өтгөн гэр бүл болж, ажил албандаа өөрийн мөртэй, хамт олонтой, ах дүүсээс дутуугүй найз нөхөдтэй болсноо баяртайгаар хуучлав. Хошууч С.Сод-Эрдэнэ энэ хугацаанд ангидаа салааны захирагчаас шаталсан зарчмаар зургаан албан тушаал дэвшиж ажилласан байна. Тэрээр 2013 онд Афганистан Улсад, 2020-2021 онд БНӨСУ-д энхийг сахиулах үүрэг гүйцэтгэж, 2015, 2016 онд Канад болон Францад хэлний мэдлэгээ дээшлүүлж, ротын захирагчийн дамжаанд суралцаж төгсжээ. Франц болон англи хэлтэй. "Франц хэлээ ашиглахгүй байсаар "зэвэрч" байгаа юм биш биз дээ" гэхэд "Цэргийн хүн тушаалаар" гэдэг товчхон хариултыг өгнө лээ.

Хошууч энэ үедээ нэгэн эрхмийг онцлон дурдсан нь 2013 онд

Харин түүний гэргий хүнсний технологич мэргэжилтэй, Дорнодод нөхрийгөө дагаж очсоноос хойш мэргэжлээрээ төдийлөн ажиллаж чадаагүй гэсэн нь манай бэрүүдэд тохиолддог түгээмэл байдаг бэрхшээл гэлтэй. Нэг хэсэг хүнсний үйлдвэрт чанар шалгагч хийж байсан, өдгөө бууз банш, хэрчсэн гурил хийж зарж борлуулдаг гэж байна. "Цэргийн хүний гэргий байх сэтгэгдлээсээ хуваалцаач" гэхэд "Үнэхээр сайхан. Ханийнхаа ажил мэргэжлээр, гэр бүлийнхээ төлөөх сэтгэл бүхнээр нь бахархдаг. Шагнуулахад нь хамт баярлаж, зэмлүүлэхэд нь ч дагаж гуныдаг болчихдог юм билээ. Миний хань 2017 онд байгууллагынхаа тэргүүний офицероор шалгарч, 2021 онд хошууч цолоо хүртсэн гээд биднийг баярлуулсан нь бишгүй. Шагнал өргөмжлөлөөс илүүтэй халамжтай сайн хань, аав, хамт олондоо дэм түшигтэй офицер байгаад нь л баярламаар. Бурхан шиг хүргэн заяажээ гэтэл нь айлын охиныг хайрла гэдэг үг магад миний ханьд зориулагдсан байх" хэмээн өгүүллээ.

Хошуучийнх өдгөө тус ангийн албан тушаалын 53 дугаар байранд амьдардаг, албаны байраас өрх тусгаарлая гэсэн ч хараахан амжихгүй байна, цэргийн алба хаагчдаа ажил алба, амьдралтай нь ингэж харж үздэг салбар Зэвсэгт хүчнээс өөр байхгүй, үнэхээр буянтай хамт олон гэж сонсогчоос хошууч, салааны захирагчаас албаны дарга болтол амьдралынх нь үнэнч хань, амжилтынх нь өмөг түшиг болж яваа Б.Жавзандулам бэрийнхээ талархлаар энэхүү нийтлэлээ төгсгөө.

Ахмад Д.БОЛОР

ЦЭРГИЙН ЧУУЛГЫН ЭРГЭН ТОЙРОНД...



ЦДБЭЧ-ын хамт олон Тулгар төрийн 2232, Их Монгол улс байгуулагдсаны 817 жил, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 112 жил, Ардын хувьсгалын 102 жилийн ой, Үндэсний их баяр наадмын нээлт, хаалтын ажиллагаа, хүндэтгэлийн тоглолт, Архангай аймаг байгуулагдсаны 100 жилийн ойн баяр наадмын нээлт, хүндэтгэлийн арга хэмжээ, Монголын төр, цэргийн нэрт зүтгэлтэн, ахмад дайчин, хурандаа генерал Ж.Ёндон агсны мэндэлсний 100 жилийн ойд зориулан бүтээсэн хөшөөний нээлтийн нээлтийн арга хэмжээ, Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын 100 жилийн ойн хүндэтгэлийн тоглолт, наадмын нээлт, Архангай аймгийн Хашаат, Хэнтий аймгийн Баян-Овоо сумдын 100 жилийн ойн хүндэтгэлийн арга хэмжээнүүдэд тус тус нэгдсэн болон хэсэгчилсэн бүрэлдэхүүнтэйгээр оролцон ард иргэддээ тоглолт уран бүтээлээ сурталчлан өрнүүн их ажлыг түүчээлсээр налгар намартайгаа золголоо. Үүний зэрэгцээ өвөл сургуулийн бэлтгэл ажлыг угтан төлөвлөгөөний дагуу шат дараалан хийж байгууллагын гадна болон дотор талбайн тохижилт, урсгал засварын ажлууд, сантехник, шугам сүлжээний засвар үйлчилгээнүүдийг хийж гүйцэтгэсээр байна.

Энэ өдөр чуулгын бие бүрэлдэхүүн сарын ажлаа дүгнэн хэлэлцсэн бөгөөд ЦДБЭЧ-ын дарга, хурандаа Г.Золзаяа Батлан хамгаалахын сайд, Батлан хамгаалахын Төрийн нарийн бичгийн даргын өгсөн үүрэг чиглэлийг нийт бие бүрэлдэхүүнд тодотгон тайлбарлаж, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны давтан зааварчилгаа, хөдөө орон нутагт зорчих замын хөдөлгөөний аюулгүй байдлын зааварчилгааг өгч, дараа сарын зорилго зорилтоо тодорхойлон тухайн сард тоглогдох томоохон тоглолт арга хэмжээний бэлтгэл бэлэн байдлыг хангах талаар үүрэг чиглэл өгсөн юм.

ЦДБЭЧ-ын даргын "Сарын ажлыг дүгнэх тухай" тушаалыг нийт бие бүрэлдэхүүнд танилцуулсны дараагаар "Цэргийн тангараг" давтах, Төрийн дууллаа дуулах хүндэтгэлийн ажиллагааг зохион байгууллаа.



МАНЛАЙЛАГЧ БАЙЛДАГЧ НАРТ ТҮРҮҮЧ ЦОЛ ОЛГОЛОО



7 дугаар сарын 25-ны өдөр Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийн Сургалтын төвд явагдаж байгаа "Оюутан-цэрэг 2023" сургалтын салаадын бага дарга нарыг тодруулж, түрүүч цол олгож, шилдэг салаадуудыг тодруулав. Өнгөрсөн 7 хоногийн хугацаанд жигдрэл, дүрмийн мэдлэг, жагсаал зэрэг олон шалгуураар I ротын III салаа "Шилдэг салаа"-гаар тодорч, II ротын I салаа, IV ротын I салаа нар удаах байруудыг эзэллээ.

Дэслэгч Б.ТЭНГИС

Гэрэл зураг түүх өгүүлнэ



МОНГОЛ ЦЭРЭГ-ДЭЛХИЙН ЦЭРЭГ